



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

᠑᠐᠒᠕ оны 1᠗ сарын ᠒᠐ өдөр

Дугаар 4/2᠐

Номгон

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны  
үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, 48 дугаар зүйлийн 48.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай 9 дүгээр зүйлийн 9.11.1, 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур, үзүүлэлт, зорилтот түвшинг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Т.Норов)-д даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ



642301084

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны  
өдрийн 4/26 дугаар тогтоолын нэгдүгээр  
хавсралт



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

**НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**1.1.Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.**

**1.1.1.“Уламжлалт мал аж ахуй, аялал жуулчлалын төрөлжсөн бүс” болно**

1.1.1.1.Хангайн болон Баруун бүсийн аймгуудыг нэгтгэсэн тээвэр логистикийн төвийг Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсэд байгуулж, орон нутгийн иргэдийн жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээг өргөжүүлэх замаар бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлнэ.

1.1.1.2.Байдрагийн голыг түшиглэн 30 мВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцыг ашиглалтад оруулж, Хангайн бүсэд байгаль орчинд ээлтэй, ногоон эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгоно./үе шаттайгаар/

1.1.1.3.Хангайн бүсийн аймгуудыг хатуу хучилттай авто замаар холбож, аялал жуулчлалын шинэ маршрут бий болгон байгалийн болон түүх соёл, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.1.1.4.Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн 54,8 км хатуу хучилттай автозамыг ашиглалтад оруулж, Шаргалжуут болон бага Шаргалжуутын рашаан сувиллыг түшиглэн эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.1.1.5.Үндэсний өв, нүүдлийн соёлыг түгээн дэлгэрүүлж, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн шашин, соёл, спорт, тусгай сонирхлын зэрэг дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.1.1.6.Аялал жуулчлалын гадаад, дотоодын маркетинг, сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.

1.1.1.7.Улсын чанартай авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

1.1.1.8.Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн коллежийг түшиглэн дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.



1.1.1.9. Ингэний сүүний үйлдвэрийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр эрчимжүүлж, экспортын гол нэрийн бүтээгдэхүүнийг бий болгоно.

1.1.1.10. Бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг зохион байгуулна.

### **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА.**

**2.1. Сурч, хөгжих ая тухтай орчныг бүрдүүлж, эрдэм боловсролтой, эрүүл иргэнийг төлөвшүүлнэ.**

#### **2.1.1. Гэр бүлийн хөгжил хамгааллыг сайжруулна**

2.1.1.1. Залуу гэр бүлийг орон нутагт амьдрах боломжоор хангаж, орон сууцны ипотекийн 3 хувийн зээлд хамруулах хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.1.2. Гэр бүлд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгосон төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжинэ.

2.1.1.3. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлнэ.

2.1.1.4. Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулна.

**2.1.2. Хүүхдийн эрүүл аюулгүй орчны стандартын хангалтыг нэмэгдүүлнэ.**

2.1.2.1. Хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч, хөгжих, хамгаалуулах, оролцох эрхийг хангана.

2.1.2.2. "Хонгорын хүүхэд" хөтөлбөр боловсруулж төр, хувийн хэвшил, гэр бүл, олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

2.1.2.3. Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолны стандартыг мөрдөж шим тэжээлээр баялаг хүнс, "Өдөр бүр нэг аяга сүү", "Ингэний сүү"-гээр хангана.

2.1.2.4. Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгож, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

2.1.2.5. Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамирын гадна талбайн орчныг сайжруулна.

2.1.2.6. Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны хүртээмж, орчин, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүний эрхэд ээлтэй дотуур байр бий болгохыг дэмжинэ.

#### **2.1.3. Залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ.**

2.1.3.1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

2.1.3.2.Залуучуудын чөлөөт цагийг өнгөрүүлэх, хөгжих боломжит нөхцөлөөр хангахад зориулан хүүхэд залуучуудын хөгжлийн ордонтой болоход дэмжлэг үзүүлнэ.

**2.1.4.Ахмад настны нийгэм эдийн засгийн байдлыг сайжруулна.**

2.1.4.1.Ахмад настан, зорилтот иргэдийн асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог дэмжинэ.

2.1.4.2.Ажилтныг тэтгэвэрт гарахад бэлтгэх, ахмад настны хөгжил, хамгааллыг сайжруулах санал, санаачилгыг дэмжинэ.

2.1.4.3.Ахмад настны зөвлөх үйлчилгээг өргөжүүлнэ.

2.1.4.4.Ахмадуудын эрүүл идэвхтэй амьдралыг дэмжих орчин нөхцөлийг сайжруулна.

**2.1.5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм эдийн засгийн байдлыг сайжруулна.**

2.1.5.1.Саадгүй байдал, тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг мөрдүүлнэ.

2.1.5.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

**2.1.6.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж өрхийн орлого /Ажлын байр/-г нэмэгдүүлнэ.**

2.1.6.1.Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

2.1.6.2.Иргэдийн туршлага, ур чадварт түшиглэн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжиж инновацад суурилсан гарааны бизнест чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2.1.6.3.Тогтвортой ажлын байрыг бий болгож хүнд, хөнгөн, жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч, аж ахуйн нэгжүүдийн ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.1.6.4.Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, сайн дурын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.

2.1.6.5.Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

2.1.6.6.Аймгийн жижиг дунд бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж, жижиг дунд болон хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлнэ.

2.1.6.7."Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг үргэлжлүүлж, "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



### **2.1.7.Инженерийн дэд бүтэц бүхий орон сууцаар хангагдсан өрхийн тоог нэмэгдүүлнэ.**

2.1.7.1.Аймгийн төвийн ашиглалтын шаардлага хангахгүй орон сууц болон гэр хорооллын бүсийг дахин төлөвлөлтөд хамруулна.

2.1.7.2.Улс болон Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, барилга байгууламжийг барих, шинэчлэх, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.1.7.3.Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсэд эрчим хүчний хэмнэлттэй, төвлөрсөн инженерийн шийдэл бүхий жишиг хорооллыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгоно.

2.1.7.4.Нийтийн орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, сууц өмчлөгчдийн холбоонд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

2.1.7.5.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шаардлагатай сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ.

2.1.7.6.Аймгийн хэмжээнд 2500-аас доошгүй айл өрхийг орон сууцаар хангана.

2.1.7.7.Аймгийн төвд 35 мВТ хүчин чадал бүхий Дулааны станцыг ашиглалтад оруулна.

2.1.7.8.Аймгийн төвийн II хэлхээний инженерийн шугам сүлжээг бүрэн шинэчилнэ.

2.1.7.9.Баянхонгор сумын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.

2.1.7.10.“Сумын төвийн шинэчлэл” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.1.7.11.Баянхонгор сумын гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн цэвэр, дулаан, бохир усны шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ.

2.1.7.12.Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийг өргөтгөнө.

2.1.7.13.Түрээсийн Орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.

### **2.2.Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.**

#### **2.2.1.Халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна**

2.2.1.1.Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулан, иргэдийн эрүүл мэндийг дэмжиж, “Эрүүл иргэн – Хонгорын баялаг” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.1.2.Эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэхэд салбар дундын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулна

2.2.1.3.Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, бүх шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, эмчилгээний мэдээллийг дотоодод болон олон улсад цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.

2.2.1.4.Аймгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулна.

2.2.1.5.Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2.1.6.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд хяналт тавих иргэн-даатгуулагчийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.2.1.7.Наркологийн төвийг ашиглалтад оруулж үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.2.1.8.Иргэдийн эмийн гаж нөлөө, зөв зохистой хэрэглээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоог хангана.

## **2.2.2.Амьдралын зөв дадал хэвшилтэй иргэдийн тоог нэмэгдүүлнэ.**

2.2.2.1.Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим технологи, өгөгдлийн системийг хөгжүүлж, нийтийн биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулна.

2.2.2.2.Идэвхтэй хөдөлгөөн, чийрэгжүүлэх дасгал, эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн зориулалтын зам, талбай, цогцолборуудыг байгуулна.

2.2.2.3.Орон нутгийн нөөцөд түшиглэсэн олон төрөлт спортыг хөгжүүлнэ.

## **2.2.3.Иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчныг сайжруулна.**

2.2.3.1.Баянхонгор сумын цэвэр усны байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

2.2.3.2.Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулна.

2.2.3.3.Баянхонгор сумын цэвэрлэх байгууламжийг шинэчлэн, өргөтгөх асуудлыг улсын төсвийн болон олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр шийдвэрлэнэ.

2.2.3.4.Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн төслүүдийг дэмжиж, эрчим хүчний тархмал эх үүсвэрийг бий болгоно.

2.2.3.5.Жил бүр өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээнд тулгуурлан дэд станцын хүчин чадал, шугамын өргөтгөлийн ажлыг төлөвлөж, үе шаттайгаар шийдвэрлэнэ.



2.2.3.6. Үүрэн холбооны сүлжээнд холбох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

2.2.3.7. Аймгийн авто замын тэмдэг тэмдэглэгээ, гэрлэн дохиог стандартад нийцүүлэн аюулгүй байдлыг хангана.

2.2.3.8. Авто тээврийн салбарыг бодлогын баримт бичгийг батлуулж, дэмжиж хамтран ажиллана.

2.2.3.9. Баянхонгор-Цэцэрлэг хот чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлыг эхлүүлнэ.

2.2.3.10. Баянхонгор-Баянбулаг-Завхан аймгийн Отгон сумын хатуу хучилттай замын ТЭЗҮ-г боловсруулж ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.

2.2.3.11. Баянхонгор хот - Баян-Овоо сум - Галуут сум - Жаргалант сум - Заг сум - Гурванбулаг сум – Архангай аймгийн Хангай сум - Босоо тэнхлэгийн мянганы замыг холбосон 350 км хатуу хучилттай авто замын ажлыг эхлүүлнэ.

2.2.3.12. Баянхонгор хот – Шинэжинст сумын төв хүртэлх 230 км хатуу хучилттай авто замын ажлыг эхлүүлнэ.

2.2.3.13. Агаарын тээврийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулахад орон нутгийн зүгээс хамтран ажиллана.

2.2.3.14. Байгаль орчинд ээлтэй ногоон тээврийн хэрэгслийг хэрэглээнд нэвтрүүлж, цахилгаан машин цэнэглэх станц байгуулна.

### **2.3. Боловсролын чанарыг дээшлүүлнэ.**

#### **2.3.1. Боловсролын чанарыг тэгш хүртээмжтэй болгоно.**

2.3.1.1. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд хамруулж, сурах орчин нөхцлийг бүрэн шийдвэрлэж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд барина.

2.3.1.2. Багшийн ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, мэргэжлийн нэр хүндийг өсгөхийн зэрэгцээ хариуцлага, ур чадварыг дээшлүүлж, хөгжлийг дэмжинэ.

2.3.1.3. Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааг дэмжиж, иргэн бүр суралцах тэгш боломжийг бүрдүүлнэ.

2.3.1.4. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын агуулгыг орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

2.3.1.5. Хиймэл оюун ухаан дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлж хөгжүүлнэ.

### **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

#### **3.1. Бие даасан аймаг болохыг зорино.**

##### **3.1.1. Аймгийн орон нутгийн орлогын хэмжээг 30 хувиар нэмэгдүүлнэ**

3.1.1.1.Татварын орлогын бааз суурийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

3.1.1.2.Хөгжлийн зорилт, төсвийн уялдааг хангасан үр дүнд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлнэ.

3.1.1.3.Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

**3.1.2.Гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо хангана.**

3.1.2.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Баянхонгор суманд байгуулагдсан Ингэний сүүний үйлдвэр, 1000 тн-ын зоорь, өвлийн хүлэмж, Өлзийт сумын өвлийн хүлэмжийн үйл ажиллагааг жигдрүүлнэ.

3.1.2.2.Сумдад мах бэлтгэн нийлүүлэх үйлдвэр, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, малын гаралтай түүхий эдийн үйлдвэрийг байгуулан экспортод гаргах ажлыг эхлүүлнэ.

3.1.2.3.Мал аж ахуйн биотехнологийн төвийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

3.1.2.4.Малын гаралтай түүхий эд, мах бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх дундын хоршоог орон нутгийн бүсийн хөгжлийн төвүүдэд байгуулна.

3.1.2.5.Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулна.

3.1.2.6.Орчин үеийн техник, технологи ололтыг нэвтрүүлсэн жишиг болохуйц Мал эмнэлгийн лабораторийн барилгын асуудлыг шийдвэрлэж, хүн амын хүнсний аюулгүй байдлын баталгааг хангана.

3.1.2.7.Махны үйлдвэрүүдийг түшиглэн дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг бий болгоно.

3.1.2.8.Бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах ажлыг эрчимжүүлнэ.

3.1.2.9.Атаршсан газрыг эргэлтэд оруулах замаар нийт газар тариалангийн эргэлтийн талбайг 1500 га-д хүргэх, услалтын системүүдийн засвар, шинэчлэлтийг хийж ашиглалтыг сайжруулна.

3.1.2.10.Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх зорилгоор шингэн бордооны жижиг цехийг байгуулж хэрэглээг нэмэгдүүлнэ.

3.1.2.11.Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран үр сортын туршилт судалгааны ажлыг эхлүүлж, төмс, хүнсний ногооны үрийн нөөц сан бий болгоно.



3.1.2.12.Хөдөө аж ахуйн кластер төслийн хүрээнд тэжээлийн үйлдвэрийг ашиглалтад оруулж, өвс, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

### **3.1.3.Үндэсний соёлын өв тээгчдийн тоог нэмэгдүүлнэ.**

3.1.3.1.Соёлын өвийн баялаг байдлыг олон талт агуулгаар баяжуулж, хүүхэд залуучуудад өвлөн уламжлуулж, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлнэ.

3.1.3.2.Үндэсний өв уламжлал, нүүдлийн ахуй соёлыг шингээсэн уран бүтээл, дижитал контент бүтээгчдийг дэмжинэ.

3.1.3.3.Номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, сан хөмрөгийг баяжуулан, үндэсний цахим мэдээллийн санд нэгдэж, иргэн бүрийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлнэ.

### **3.1.4.Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг бий болгоно.**

3.1.4.1.Шинжлэх ухаан технологи инноваци шингэсэн үйлдвэрлэл үйлчилгээ нэвтрүүлнэ.

### **3.2.Байгаль орчны доройтлыг бууруулна.**

3.2.1.Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 7.3 хувьд хүргэнэ.

3.2.1.1."Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлнэ.

3.2.1.2.Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулна.

3.2.1.3.БНХАУ-ын Ниншя Хуй ӨЗО-той хамтран говийн бүсийг ойжуулж, газрын доройтол, цөлжилтийг бууруулна.

### **3.2.2.Усны нөөцийн ашиглалтыг сайжруулна.**

3.2.2.1.Байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсөөр хөв цөөрөм байгуулж, гадаргын усны хуримтлалыг бий болгоно.

3.2.2.2.Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, усны үнэ цэнэ, үнэлэмжийг нэмэгдүүлэн ашиглалт, хэрэглээнд хэмнэлт, дахин ашиглалтыг дэмжинэ.

3.2.2.3.Хүн амыг шаардлага хангасан ундны усаар хангах хайгуул судалгааны ажлыг шаардлагатай сумдад хийж гүйцэтгэнэ.

### **3.2.3.Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулна.**

3.2.3.1.Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж, менежментийг сайжруулна.

3.2.3.2.Энгийн болон аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр цуглуулах, хадгалах, дахин ашиглах, тээвэрлэх, устгах оновчтой менежментийн тогтолцоог бүрдүүлнэ.

3.2.3.3. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч орхигдсон газруудыг нөхөн сэргээнэ.

3.2.3.4. Биологийн олон янз байдлыг хамгаалах замаар амьтдын амьдрах орчныг сайжруулна.

3.2.3.5. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилгоор үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний болон үндэсний дасан зохицох төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

3.2.3.6. Агаар, хөрсний бохирдлыг бууруулна.

## **ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

**4.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.**

**4.1.1. Хүний эрхийн зөрчлийг бууруулна.**

4.1.1.1. "Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.

4.1.1.2. Жендер ба хөгжил хандлагыг төлөвшүүлнэ.

4.1.1.3. Кибер аюулгүй байдлыг хангах талаар иргэдийн мэдлэг, хандлагыг төлөвшүүлнэ.

4.1.1.4. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг сайжруулна.

**4.1.2. Аймгийн шударга байдлын түвшинг нэмэгдүүлнэ.**

4.1.2.1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

4.1.2.2. Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулж буй гэрээ, газар өмчлүүлэх, эзэмшүүлэх үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, тусгай зөвшөөрлүүдийн мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангана.

**4.1.3. Гэмт хэрэг, зөрчлийг бууруулна.**

4.1.3.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй орчныг бий болгох зорилгоор камерын хяналтын нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлж, иргэдийн аюулгүй байдлын түвшинг нэмэгдүүлнэ.

4.1.3.2. Согтууруулах ундааны эргэлтэд тавих хяналтыг сайжруулж, архи дан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын эрчимжүүлнэ.

**4.1.4. Төрийн албан хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлнэ.**

4.1.4.1. Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгаа, хүний нөөцийн стратегийг боловсруулж, чадавхыг бэхжүүлнэ.



4.1.4.2.Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад төрөөс баримтлах бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, тайлагналт, хяналтын тогтолцоог сайжруулна.

4.1.4.3.Төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санг хөгжүүлэн, байгууллага, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг ил тод болгоно.

4.1.4.4.Төрийн үйлчилгээг цахимжуулна.

4.1.4.5.Нэг аймаг - нэгдсэн стандарт хөтөлбөрийг боловсруулж, стандартыг мөрдүүлнэ.

**4.1.5.Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангана.**

4.1.5.1."SHILEN.GOV.MN" нэгдсэн системд нээлттэй мэдээллийг байршуулж, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангана.

**4.1.6.Архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг хангана.**

4.1.6.1.Төрийн болон байгууллагын архивын баримтыг бар коджуулах систем нэвтрүүлэх , баримтын бүрдүүлэлт, цахим сангийн шилжүүлэлт, ашиглалт ажлыг эрчимжүүлэх, хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг хангана.

**4.1.7.Гадаад харилцааг бэхжүүлнэ.**

4.1.7.1.Хөрш орны хот, мужуудтай соёл, боловсрол, хөдөө аж ахуй, байгаль орчин, худалдаа, эдийн засаг зэрэг салбарт хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

4.1.7.2."Гуравдагч хөрш" орнуудтай түншлэлийн харилцааг өргөжүүлж, найрсаг харилцааг гүнзгийрүүлнэ.

**4.1.8.Орон нутгийн батлан хамгаалах чадавхыг дээшлүүлнэ.**

4.1.8.1.Орон нутгийн аюулгүй байдлыг хангахад бүх талын оролцоог нэмэгдүүлнэ.

4.1.8.2.Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг хангах дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгож, иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлнэ.


4.1.8.3.Төрийн цэргийн байгууллагуудын сургалтын нэгдсэн төвийг шинээр байгуулж, оюутан цэргийн тоог шат дараатай нэмэгдүүлнэ.

4.1.8.4.Тайван цагт Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн бэлэн байдлыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.

**4.1.9.Гамшгийн эрсдэлийг бууруулна.**

4.1.9.1.Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх менежментийг сайжруулна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/26 дугаар  
тогтоолын хоёрдугаар хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

| №  | Бодлогын үндэслэл | Үр дүн   | Шалгуур үзүүлэлт                           | Хэмжих нэгж | Суурь түвшин |        | Зорилтот түвшин |       |       |       | Шалгуур үзүүлэлтийн тайлбар   | Мэдээлэл цуглуулах давтамж | Хариуцах байгууллага |                     |
|--|-------------------|--|--|-------------|--------------|--------|-----------------|-------|-------|-------|---|----------------------------|----------------------|---------------------|
|  |                   |  |  |             | он           | түвшин | 2025            | 2026  | 2027  | 2028  |   |                            | Үндсэн               | Хамтран             |
| 1  | 2                 | 3  | 4  | 5           | 6            | 7      | 8               | 9     | 10    | 11    | 12  | 13                         | 14                   | 15                  |
| <b>Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн</b> |                   |  |  |             |              |        |                 |       |       |       |   |                            |                      |                     |
| 1.1  | ЗГҮАХ-2           | Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ. | Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн | сая.төгрөг  | 2023         | 8.45   | 9.25            | 10.05 | 10.85 | 11.65 | Нэг хүнд ногдох ДНБ-ийг оны болон зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий дүнг Баянхонгор аймагт оршин суугаа хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж тооцно. | Жилд 1 удаа                | АЗДТГ                | Статистикийн хэлтэс |
| 2.1  | ЗГҮАХ-2           | Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.                     | Хүний хөгжлийн үзүүлэлт                    | Индекс      | 2023         | 0.729  | 0.743           | 0.757 | 0.770 | 0.784 | $ХХИ = \sqrt[3]{(ДН \times БИ \times ОИ)}$<br>ДН - Дундаж наслалтын индекс<br>БИ - Боловсролын индекс<br>ОИ - Орлогын индекс                          | Жилд 1 удаа                | АЗДТГ                | Статистикийн хэлтэс |
| 2.2  | ЗГҮАХ-2           | Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.                     | Хүн амын дундаж наслалт                    | Дундаж нас  | 2023         | 72.05  | 72.47           | 72.89 | 73.31 | 73.73 | Шинээр төрсөн (төрөх үеийн) хүүхдийн цаашид үргэлжлэн амьдрах дундаж хугацааг (жил) хэлнэ.  | Жилд 1 удаа                | АЗДТГ                | Статистикийн хэлтэс |
|  |                   |  | Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ      | Хувь        | 2023         | 95     | 95.5            | 96    | 97    | 98    | 5 настай хүүхдийг үндсэн болон хувилбарт сургалтад хамруулсан байдлын үнэлгээ   | Жилд 1 удаа                | Боловсролын газар    | АЗДТГ               |



| 1                         | 2           | 3  | 4   | 5       | 6    | 7    | 8   | 9    | 10   | 11  | 12  | 13            | 14                         | 15                                  |
|---------------------------|-------------|--|---|---------|------|------|-----|------|------|-----|---|---------------|----------------------------|-------------------------------------|
| 2.3                       | ЗГҮАХ-2     | Боловсролын чанарыг дээшлүүлнэ.                                    | Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж  | Оноо    | 2023 | 499  | 503 | 506  | 512  | 515 | Төгсөгчдийн оноог дундажтай харьцуулна.   | Жилд 1 удаа   | Боловсролын газар          | АЗДТГ                               |
|                           |             |  | Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин | хувь    | 2023 | 65   | 67  | 68   | 69   | 70  | Ажил хөлөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хувь   | Жилд 2 удаа   | Боловсролын газар          | АЗДТГ                               |
| 3.1                       | ЗГҮАХ-3     | Бие даасан аймаг болохыг зорино.                                   | Орон нутгийн урсгал зардалд орон нутгийн орлогын хувь                               | Хувь    | 2023 | 40   | 50  | 55   | 60   | 70  | Тухайн жилийн төсвийн урсгал зардалд эзлэх орон нутгийн орлогын хувь  | жилд 1 удаа   | АЗДТГ                      | Татварын газар                      |
| 3.2                       | ЗГҮАХ-3     | Байгаль орчны доройтлыг бууруулна.                                 | Цөлжилтийн хувь   | хувь    | 2023 | 98.1 | 98  | 97.7 | 97.4 | 97  | Цөлжилтөд өртсөн газар нутгийн хувь   | Жилд 1 удаа   | АЗДТГ                      | Байгаль орчны газар                 |
|                           |             |  | PM2.5 тоосонцорын жилийн дундаж агууламж  | м кг/м3 | 2023 | 41   | 40  | 39   | 38   | 37  | Суурь түвшингээс буурсан дүнгээр  | Жилд 1 удаа   | Байгаль орчны газар        | Ус, цаг уур, орчны шинжилгээний төв |
| 4.1                       | ЗГҮАХ-4     | Төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ. | Иргэдийн сэтгэл ханамжийн тоо   | Оноо    | 2023 | 3.5  | 3.5 | 3.6  | 3.7  | 3.8 | urgen.gov.mn судалгааны систем  | Жилд 1 удаа   | ЗДТГ                       | Төрийн байгууллагууд                |
| <b>Хөтөлбөрийн үр дүн</b> |             |  |   |         |      |      |     |      |      |     |   |               |                            |                                     |
| 1.1.1                     | ЗГҮАХ-1.3.1 | Уламжлалт мал аж ахуй, аялал жуулчлалын төрөлжсөн бүс болно.       | Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь                      | хувь    | 2023 | 51.5 | 52  | 52.5 | 53   | 54  | Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ | Жилд нэг удаа | Хүнс, хөдөө аж ахуйн газар | АЗДТГ                               |

| 1     | 2       | 3  | 4                             | 5    | 6    | 7     | 8     | 9     | 10    | 11    | 12   | 13            | 14   | 15    |
|-------|---------|--|-------------------------------|------|------|-------|-------|-------|-------|-------|--|---------------|--|-------|
|       |         |  | Жуулчдын тоо                  | тоо  | 2022 | 16089 | 20000 | 30000 | 40000 | 50000 | Тухайн жилд ирсэн жуулчдын тоо   | Жилд нэг удаа | Соёл урлаг, аялал жуулчлал залуучуудын газар | АЗДТГ |
| 2.1.1 | ЗГҮАХ-2 | Гэр бүлийн хөгжил хамгааллыг сайжруулна.                       | Гэр бүл цуцлалт               | тоо  | 2023 | 54    | 50    | 48    | 45    | 38    | Хуулийн дагуу гэр бүл цуцалсан тоо   | Жилд 1 удаа   | Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар   | АЗДТГ |
| 2.1.2 | ЗГҮАХ-2 | Хүүхдийн эрүүл аюулгүй орчны стандартын хангалтыг нэмэгдүүлнэ. | Орчны стандартын хангалт      | хувь | 2023 | 45    | 50    | 55    | 60    | 65    | MNS 6781:2019, ЕБС-ын сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага, MNS 6782:2019, ебс-ын орчны аюулгүй байдалд тавих ерөнхий шаардлага, MNS 6799:2019, сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилтийн дундаж | Жилд 1 удаа   | Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар   | АЗДТГ |
| 2.1.3 | ЗГҮАХ-2 | Залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ.                              | Залуучуудын оролцооны түвшин  | Хувь | 2023 | 5     | 10    | 15    | 20    | 25    | Сургалт, нөлөөллийн арга хэмжээ, сайн дурын ажил оролцсон залуучуудыг нийт залуучуудад харьцуулсан хувь  | Жилд 1 удаа   | Соёл урлаг, аялал жуулчлал залуучуудын газар | АЗДТГ |
| 2.1.4 | ЗГҮАХ-2 | Ахмад настны нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулна.         | Ахмад настны оролцооны түвшин | Хувь | 2023 | 28.6  | 31.0  | 32.0  | 33.0  | 35.0  | Ахмадуудад зориулсан үйл ажиллагаанд хамрагдсан ахмад настны тоог нийт ахмад настны тоонд харьцуулан гаргана   | Жилд 1 удаа   | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар       | АЗДТГ |



| 1     | 2       | 3   | 4   | 5    | 6    | 7    | 8    | 9    | 10   | 11   | 12  | 13          | 14                                     | 15                  |
|-------|---------|---|---|------|------|------|------|------|------|------|---|-------------|--|---------------------|
| 2.1.5 | ЗГҮАХ-2 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулна. | Тусгай хэрэгцээт хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамран сургалтын хувь | хувь | 2023 | 45   | 46   | 48   | 49   | 50   | СӨБ-д хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг 2-5 насны нийт хөгжлийн бэрхшээлтэй /сурах боломжтой/ хүүхдэд харьцуулсан харьцаа  | Жилд 2 удаа | Боловсролын газар                      | АЗДТГ               |
|       |         |   | Тусгай хэрэгцээт хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалтын хувь   | хувь | 2023 | 68.4 | 69   | 70   | 71   | 72   | ЕБС-д хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг 6-18 насны нийт хөгжлийн бэрхшээлтэй /сурах боломжтой/ хүүхдэд харьцуулсан харьцаа | Жилд 2 удаа | Боловсролын газар                      | АЗДТГ               |
|       |         |   | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн хувь                       | Хувь | 2023 | 14.0 | 15.0 | 16.0 | 18.0 | 20.0 | Ажил эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөр эрхлэх боломжтой нийт хөгжлийн бэрхшээлтэй хүнд харьцуулсан харьцаа             | Жилд 2 удаа | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | АЗДТГ               |
| 2.1.6 | ЗГҮАХ-2 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж өрхийн оролгыг                               | Ажиллах хүчний оролцооны түвшин   | Хувь | 2023 | 69.0 | 69.8 | 70.6 | 71.0 | 71.9 | Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно   | Жилд 1 удаа | АЗДТГ                                  | Статистикийн хэлтэс |
|       |         |   | Ажилгүйдлийн түвшин   | хувь | 2023 | 8.2  | 8.0  | 7.8  | 7.6  | 7.3  | Ажилгүйдлийн түвшин гэдэг нь ажилгүйдлийн түвшин буюу эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-д ажилгүйчүүдийн эзлэх хувь нь        | Жилд 1 удаа | АЗДТГ                                  | Статистикийн хэлтэс |

| 1     | 2           | 3  | 4  | 5                           | 6    | 7       | 8      | 9      | 10     | 11     | 12   | 13          | 14                  | 15   |
|-------|-------------|--|--|-----------------------------|------|---------|--------|--------|--------|--------|--|-------------|---------------------|--|
|       |             | нэмэгдүүлнэ.   | Хөдөлмөр эрхэлтийн түвшин  | хувь                        | 2023 | 66.0    | 66.3   | 66.6   | 66.9   | 67.0   | Хөдөлмөр эрхлэлтийн түвшин=Ажиллагчид/Хөдөлмөрийн насны хүн ам×100%              | Жилд 1 удаа | АЗДТГ               | Статистикийн хэлтэс                            |
|       |             |  | Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан хувь                | Хувь                        | 2023 | 60.2    | 60.4   | 60.6   | 60.8   | 70.00  | Нийгмийн даатгалд хамрагдаж байгаа хүнийг ажиллах хүчинд харьцуулж тооцно        | Жилд 1 удаа | АЗДТГ               | Статистикийн хэлтэс                            |
| 2.1.7 | ЗГҮАХ-1.1.3 | Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн тоог нэмэгдүүлнэ. | Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь | хувь                        | 2023 | 38.5    | 40     | 42.5   | 43.1   | 44.8   | Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь | Жилд 1 удаа | АЗДТГ               | Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар |
| 2.2.1 | ЗГҮАХ-2     | Халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна.                             | Хоол боловсруулах тогтолцооны өвчин  | 10000 хүн амд ногдох түвшин | 2023 | 1,496.4 | 1495.0 | 1494.0 | 1450.0 | 1410.0 | 10000 хүн амд ногдох түвшин  | Жилд 1 удаа | Эрүүл мэндийн газар | АЗДТГ  |
|       |             |  | Амьсгалын тогтолцооны өвчин  | 10000 хүн амд ногдох түвшин | 2023 | 2109.5  | 2109.4 | 2109.3 | 2009.2 | 1980.1 | 10000 хүн амд ногдох түвшин  | Жилд 1 удаа | Эрүүл мэндийн газар | АЗДТГ  |
|       |             |  | 10.000 хүн амд вирус гепатитын өвчлөл В, С                                       | 10000 хүн амд ногдох түвшин | 2023 | 0.6     | 0.5    | 0.4    | 0.3    | 0.2    | 10000 хүн амд ногдох түвшин  | Жилд 1 удаа | Эрүүл мэндийн газар | АЗДТГ  |
|       |             |  | 10.000 хүн амд сүрьеэгийн өвчлөл   | 10000 хүн амд ногдох түвшин | 2023 | 3.61    | 3.6    | 3.2    | 2.9    | 2.6    | 10000 хүн амд ногдох түвшин  | Жилд 1 удаа | Эрүүл мэндийн газар | АЗДТГ  |
|       |             |  | Бэлгийн замаар дамжих халдварын эзлэх хувь                                       | Хувь                        | 2023 | 56.0    | 55.50  | 55.0   | 52.0   | 49.0   | Нийт халдварт өвчинд бэлгийн замаар халдварын хувиар тооцно.                     | Жилд 1 удаа | Эрүүл мэндийн газар | АЗДТГ  |
|       |             |  | Зүрх судасны тогтолцооны өвчин   | 10000 хүн амд ногдох түвшин | 2023 | 816.4   | 816    | 815.5  | 815    | 814.5  | 10000 хүн амд ногдох түвшин  | Жилд 1 удаа | Эрүүл мэндийн газар | АЗДТГ  |



| 1      | 2       | 3  | 4  | 5                           | 6    | 7     | 8     | 9     | 10    | 11    | 12   | 13                 | 14   | 15   |
|--------|---------|--|--|-----------------------------|------|-------|-------|-------|-------|-------|--|--------------------|--|--|
|        | ЗГҮАХ-2 | Халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна.         | Хорт хавдар  | 10000 хүн амд ногдох түвшин | 2023 | 17.7  | 17.5  | 17.2  | 16.8  | 16.5  | 10000 хүн амд ногдох түвшин  | Жилд 1 удаа        | Эрүүл мэндийн газар                              | АЗДТГ  |
|        |         |  | Осол гэмтэл  | 10000 хүн амд ногдох түвшин | 2023 | 130.9 | 130.7 | 130.6 | 125.3 | 121.0 | 10000 хүн амд ногдох түвшин  | Жилд 1 удаа        | Эрүүл мэндийн газар                              | АЗДТГ  |
|        |         |  | 100.000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин         | промилль                    | 2023 | 0     | 0     | 0     | 0     | 0.0   | 10000 хүн амд ногдох түвшин  | Жилд 1 удаа        | Эрүүл мэндийн газар                              | АЗДТГ  |
|        |         |  | 1.000 амьд төрөлтөд ногдох нялхасын эндэгдлийн түвшин        | промилль                    | 2023 | 8     | 0     | 0     | 0     | 0.0   | 1000 хүн амд ногдох түвшин   | Жилд 1 удаа        | Эрүүл мэндийн газар                              | АЗДТГ  |
| 2.2.2  | ЗГҮАХ-2 | Амьдралын зөв дадал хэвшилтэй иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | Эрүүл амьдралын хэв маягтай иргэдийн нийт иргэдэд эзлэх хувь | Хувь                        | 2023 | 15    | 20    | 25    | 28    | 30    | Сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ. | Жилд 2 удаа        | Биеийн тамир, спортын газар, Эрүүл мэндийн газар | АЗДТГ  |
| 2.2.3. | ЗГҮАХ-2 | Иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчныг сайжруулна.        | Цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрхийн эзлэх хувь          | хувь                        | 2023 | 65.4  | 68    | 69.5  | 72    | 74    | өссөн дүнгээр  | Жилд нэг удаа      | Баянхонгор Эрчим хүч ЦТХХК                       | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |
|        |         |  | Шинээр баригдах хатуу хучилттай автозамын урт                | км                          | 2023 | 0     | 10    | 11.3  | 66.1  | 66.1  | өссөн дүнгээр  | Жилд нэг удаа      | АЗДТГ  |  |
|        |         |  | Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь                  | хувь                        | 2022 | 1.65  | 5     | 10    | 20    | 30    | өссөн дүнгээр  | Жилд нэг удаа      | Сумын Засаг даргын Тамгын газар                  | АЗДТГ, Байгаль орчны газар                             |
|        |         |  | "Сайн багшийг таны дэргэд" цогц арга хэмжээний хэрэгжилт     | Хувь                        | 2024 | 0     | 30    | 50    | 80    | 100   | Арга хэмжээнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийн хувиар   | Хагас бүтэн жилээр | Боловсролын газар                                | АЗДТГ  |

| 1      | 2       | 3   | 4  | 5    | 6    | 7     | 8     | 9     | 10    | 11    | 12  | 13          | 14                         | 15    |
|--------|---------|---|--|------|------|-------|-------|-------|-------|-------|---|-------------|----------------------------|-------|
| 2.3.1  | ЗГҮАХ-2 | Боловсролын чанарыг тэгш хүртээмжтэй болгоно.                                   | Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, хувилбарт сургалтад хамруулсан түвшин | Хувь | 2024 | 51.8  | 57    | 60    | 69    | 75    | СӨБ, ЕБ-ын үйлчилгээнд хамрагдаж буй ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн эзлэх жин /малчдын, хөгжлийн бэрхшээлтэй/  | Жилээр      | Боловсролын газар          | АЗДТГ |
|        |         |   | Орон нутагт бэлтгэсэн хүний нөөцөд үзүүлсэн дэмжлэг  | тоо  | 2024 | 19    | 25    | 30    | 35    | 40    | Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид үзүүлсэн сургалтын дэмжлэгийн тоогоор   | жилээр      | Боловсролын газар          | АЗДТГ |
| 3.1.1. | ЗГҮАХ-3 | Аймгийн орон нутгийн орлогын хэмжээг 30 хувиар нэмэгдүүлнэ.                     | Орлогын өсөлтийн хувь  | хувь | 2023 | -     | 5     | 15    | 20    | 30    | Төсвийн орлогын гүйцэтгэлийг суурь түвшинтэй харьцуулсан зөрүүгээр тооцно.  | жилээр      | Татварын газар             | СТСХ  |
| 3.1.2  | ЗГҮАХ-3 | Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотооддоо хэрэгцээний хангамжийг нэмэгдүүлнэ. | Мах  | хувь | 2023 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Хүнсний хангамж тооцох аргачлал"-аар тооцно. | Жилд 1 удаа | Хүнс, хөдөө аж ахуйн газар | АЗДТГ |
|        |         |   | Сүү  | хувь | 2023 | 50    | 60    | 65    | 70    | 70    |   | Жилд 1 удаа | Хүнс, хөдөө аж ахуйн газар | АЗДТГ |
|        |         |   | Төмс   | хувь | 2023 | 53.6  | 54    | 56    | 58    | 60    |   | Жилд 1 удаа | Хүнс, хөдөө аж ахуйн газар | АЗДТГ |
|        |         |   | Хүнсний ногоо  | хувь | 2023 | 11.8  | 12    | 13    | 14    | 15    | Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 74   | Жилд 1 удаа | Хүнс, хөдөө аж ахуйн газар | АЗДТГ |



| 1     | 2       | 3  | 4   | 5       | 6    | 7     | 8     | 9     | 10    | 11    | 12   | 13             | 14   | 15  |
|-------|---------|--|---|---------|------|-------|-------|-------|-------|-------|--|----------------|--|---|
|       |         |  | Гурилан<br>бүтээгдэхүүн                           | хувь    | 2023 | 30    | 45    | 50    | 60    | 60    | дүгээр тушаалаар<br>баталсан "Хүнсний<br>хангамж тооцох<br>аргачлал"-аар тооцно. | Жилд 1<br>удаа | Хүнс, хөдөө аж<br>ахуйн газар                            | АЗДТГ   |
|       |         |  | Өндөг   | хувь    | 2023 | 15    | 30    | 35    | 40    | 40    |  | Жилд 1<br>удаа | Хүнс, хөдөө аж<br>ахуйн газар                            | АЗДТГ   |
| 3.1.3 | ЗГҮАХ-3 | Үндэсний соёлын<br>өв тээгчдийн тоог<br>нэмэгдүүлнэ.                                   | Өв тээгчдийн тоо                                  | Тоо     | 2023 | 3     | 5     | 5     | 5     | 5     | Өв тээгчдийн тоо   | Жилд 1<br>удаа | Соёл урлаг,<br>аялал<br>жуулчлал<br>залуучуудын<br>газар | АЗДТГ   |
